

БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ШАГДАРСҮРЭН ОВОГТОЙ НАРАНЦЭЦЭГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах							
1.	Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр	-	Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар бууруулсан байна.	Үнийн нэгдмэл байдлыг хангах, барааны үнийг хянахад зарцуулах цаг хугацааг багасгах зорилгоор хэлцлийн үнийн баазад зарим барааны үнийг нэмж оруулах хүсэлтийг ГЕГ-ын БАҮ-ний хэлтэст хүргүүлэн ажилласан. Үүнд: - Ариун цэврийн хэрэглэлийн үнэ хэлцлийн үнийн баазад нэмүүлсэн. - 1604.14.00 туна загас үнэ баазад хэт бага байгааг БАҮХ-ийн ГУБ Сакенд мэдэгдсэн. - 4011.20.30 автоачигчийн дугуйны үнийг хянаж өгөхийг мөн хэлсэн. - Солонгос улсын гарал үүсэлтэй Хэв хашмалын үнийг интенэт үнээр хянаж цаг хугацаа ихээр зарцуулах, өөр өөр үнэ хэрэглэх зэрэг алдаа гарч байсан тул хэмжээ тус бүрээр хэлцлийн үнийн баазад үнэ оруулсан. - 6810 бүлгийн тарифын ялгавартай барааны онцлог шинжээр гарын авлага хийн ГУБ нарт танилцуулсан. - 2024.05.09-ны 62 тоот дотоод зурвасаар МТГ-т өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулахын тулд КАЙС СЕПС системд ойрын хугацаанд хийх шаардлагатай өөрчлөлтийн санал өгсөн. - 2024 оны 11 сарын 04-ний өдөр №159 тоот дотоод зурвасаар CAIS програмд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн өөрчлөлт оруулах талаар санал хүргүүлсэн. - 2024 оны 11 сарын 22-ны өдөр №169 тоот дотоод зурвасаар экспортын гаалийн бүрдүүлэлтийг хийх програмын шийдлийн талаар	2024.01.01 - 2024.12.10	

2.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. 2. ГБМ-ний үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, улирал бүр /нийт 2 удаа/ засварт буцаалтад судалгаа, дүн шинжилгээ хийж, санал гарган БАҮХ-т хүргүүлсэн байна.	1. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-д БМ Барааны дагалдах бичиг баримттай их хувиар харьцаж байгаа тул бичиг баримтын тамга, гарын үсэг болон бусад бүрдэл хэсгийг сайтар нягтлан оруулах. Дагалдах бичиг баримт илт хуурамч засварласан баримт хавсаргаснаас үүсэх хариуцлагыг БМ-д хүлээлгэх. Мөн цахим архив үүсгэхтэй асуудлыг тусгаж холбогдох саналыг өгсөн. 2. Сүүлийн үед БНХАУ-аас импортлох суудлын автомашины тоо эрс нэмэгдэж байгаа бөгөөд 2023 оны нэгдүгээр улиралд 325 автомашин импортолж байсан бол 2024 оны мөн үед даруй 43 хувиар өсч 568 ширхэг суудлын автомашин импортлосон байна. Хятад автомашины импорт нэмэгдэхийн хирээр гаалийн бүрдүүлэлтэд анхаарах зүйлс гарч байна. Тухайн автомашины оноосон нэр, унификаци дутуу бичих алдаа гарч байна. Энэ алдаа нь БНХАУ-ын автомашины техникийн гэрчилгээнд автомашины марк, модель загварын нэр байхгүй, зөвхөн үйлдвэрлэгч буюу брэнд нэр л байдаг. Мөн хилээс дагалдаж буй худалдааны баримт дээр мөн адил тухайн автомашины мэдээлэл бүрхэг байдагтай холбоотой. 2023 оны нэгдүгээр улиралд мэдүүлсэн хятад суудлын автомашины 19 хувь, 2024 оны нэгдүгээр улиралд импортлосон автомашины 4 хувь нь дээр дурдсан алдаатайгаар мэдүүлэгдсэн байна. Иймд БНХАУ-аас импортлогдож байгаа БТКУС-ийн 8703-т ангилагдах суудлын автомашины бүрдүүлэлт хийхдээ тухайн автомашины оноосон нэр, унификацийг бүрэн гүйцэт зөв бичих нь бараагаа таньж мэдэх, ангиллын кодыг зөв тодорхойлох улмаар гаалийн үнийг зөв тогтоож МУ-ын гаалийн болон НӨАТ, онцгой татварыг зөв ногдуулах төдийгүй статистик мэдээ гарахад чухал ач холбогдолтой юм. - Мөн доорх Автомашины гаалийн мэдүүлгийн оноосон нэр, унификацийг бүрэн гүйцэт зөв бичих. - Автомашины 4 тал зургийг тохирсон зайнаас авсан гаргацтай тод харагдахуйцаар мэдүүлэгт хавсаргах. - VIN17.com сайтаар автомашины арлын дугаарыг шалгаж оноосон нэр үйлдвэрлэсэн оныг нягталж хэвших. - Автомашины үнийг хянахдаа дор дурдсан цахим хуудсуудыг ашиглах шаардлагатай байна. Үүнд: - https://www.dongchedi.com/ 懂车帝 - https://www.che168.com/ 车168 - https://price.yiche.com/ 易车汽车报价	2024.01.01 - 2024.12.10	
----	--	-------------------------	--	---	--	--

					зөвлөмжүүдийг ГБМ-д хүргүүлж ажилласан.		
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Сургалт зохион байгуулах	1. Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан 18 сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн байна. 2. 2024.03.25-2024.03.29-ний хооронд УБ хотод зохион байгуулагдсан ДГБ, Японы гаалийн байгууллагаас хамтран зохион байгуулсан Гарал үүслийн сургалтад хамрагдаж сертификат авсан. Энэхүү сургалтын дагуу БНТ-ийн нийт ГУАБ, ГУБ нарт сургалт зохион байгуулсан. 3. 72, 73-р бүлгийн барааны талаар сургалтыг хийсэн.	2024.01.01 - 2024.12.10	
4.	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн чиг үүргийн хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж байна. 2024 оны ХОМэдүүлгээ хугацаанд нь тайлагнасан.	2024.01.01 - 2024.12.10	
Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх							
1.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна.	2023 оны зохих горимд байршаагүй гаалийн бүрдүүлэлтийг дуусгавар болгох ажилд оролцон мэдүүлгүүдийг зохих төлөвт оруулан ажилласан. 2024 оны эхний 11 сарын байдлаар түр горимын 10-н кодоор 230891.6 мян.ам.долларын үнийн дүн бүхий бараа, тээврийн хэрэгсэлд 7155 гаалийн мэдүүлгээр түр горимын оруулах болон гаргах бүрдүүлэлт хийгдсэн. /экспортын 733 мэдүүлэг 101986.6 мян.ам.доллар, импортын 6422 мэдүүлэг 128905.0 мян.ам.дол/ Гаалийн тухай хуулийн 95.1-р зүйлд зааснаар гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан, гаргасан барааг бүрмөсөн орох горимд шилжсэнээр 2024 оны эхний 11 сард 30 тэрбум 584 сая төгрөгийг татвар улсын төсөвт төвлөрсөн байна. Импортын түр горимын мэдүүлгийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 5.5 хувь өссөн боловч барааны үнийн дүн 10.2 хувь, татварын дүн 2.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны 8 дугаар сард зохион байгуулсан "Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хууль бус худалдаатай тэмцэх аян"-ны хүрээнд 2020-2024 оны түр хугацаагаар импортлогдсон барааны	2024.01.01 - 2024.12.10	

					судалгааг хийсэн ба үүний үр дүнд хугацаа хэтэрсэн 36 гаалийн мэдүүлгийн жагсаалт гарган холбогдох газар, хороонд мэдэгдэн заавар, зөвлөгөөг өгч ажилласнаар 20 мэдүүлэг түр горимын хаалтын бүрдүүлэлтийг хийсэн. 2024 эхний эхний хагас жилийн байдлаар шүүхийн шатанд, Хорио цээрийн хяналтад байгаагаас бусад мэдүүлгүүдийг зохих төлөвт оруулан ажиллаа.		
2.	Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил	Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн	-	1. Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.	Тайлант хугацаанд: 02-2091011-24-130249 мэдүүлэгт 28 874 366 төгрөг. 04-2231003-24-130119 мэдүүлэгт 3,446,273 төгрөг. 02-2111004-24-130350 мэдүүлэгт 1 447 535 төгрөг. 02-2151011-24-132324 мэдүүлэгт 8,172,299.82 төгрөг. 02-2091018-24-130394 мэдүүлэгт 5,720,729 төгрөг. 02-2091011-24-130313 мэдүүлэгт 36 487 286 төгрөг. 02-2151008-24-131279 мэдүүлэгт 3 966 000 төгрөг. 02-2141007-24-131392 мэдүүлэгт 10 000 000 төгрөг. 02-2091011-24-130259 мэдүүлэгт 1 000 000 төгрөг. 02-2091010-24-131048 мэдүүлэгт 6 000 000 төгрөг. 02-2151011-24-132486 мэдүүлэгт 4 000 000 төгрөг. 02-2091011-24-130249 мэдүүлэгт 1 038 826 төгрөг. 02-2091006-24-131168 мэдүүлэгт 5 315 837 төгрөг. 03-2231003-24-130202 мэдүүлэгт 7,622,253 төгрөг. 02-2091006-24-131173 мэдүүлэгт 2 128 771 төгрөг. 04-2151005-24-130685 мэдүүлэгт 6 986 237 төгрөг. 03-2141016-24-130213 мэдүүлэгт 7 849 107 төгрөг. 03-2151009-24-131450 мэдүүлэгт 13,555,447 төгрөг. 02-2091011-24-130679 мэдүүлэгт 9,862,233 төгрөг. 03-2141016-24-130372 мэдүүлэгт 627,544 төгрөг. 03-2141018-24-131198 мэдүүлэгт 2,896,842 төгрөг. 03-2161001-24-131726 мэдүүлэгт 3,272,798 төгрөг. 03-2161001-24-132283 мэдүүлэгт 2 622 862 төгрөг. 03-1310543-24-100002 мэдүүлэгт 2,614,794 төгрөг. 03-2121001-24-131858, 03-2121001-24-131859 мэдүүлэгт 6 288 084 төгрөг. 02-2141008-24-131451 мэдүүлэгт 13,108,155 төгрөг. 14-2091008-24-130900 мэдүүлэгтэй Талын цэнхэг трейд ХХК-ний мэдүүлсэн Бетонон шонгийн барааны кодыг буруу буюу бага тарифтай кодоор мэдүүлсэн алдааг засуулсан. Зөрчил: 03-2111004-24-131061 мэдүүлэгт эй Түмэнтөмөрт ХХК-ний мэдүүлсэн төмрийн үнийг буруу хянасан алдааг засуулан, ААН-д	2024.01.01 - 2024.12.10	

					ЗТХ-ийн дагуу торгуулийн арга хэмжээ авсан. Нэмсэн татвар 2,865,794 төгрөг. Шийтгэлийн хуудасны дугаар №0094032 2 000 000 төгрөг. 03-2091017-24-132163 тоот мэдүүлэгтэй Професионалсаплай сервис ХХК-ний мэдүүлсэн төмрийн код Цул төмөр байхад оноосон нэрийг Гөлмөн төмөр гэж мэдүүлсэн алдааг засуулан, ГБМэргэжилтэнд зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ аван ажиллаа. Шийтгэлийн хуудасны дугаар: №0094031 300 000 төгрөг. Нийт 29 мэдүүлгээр 197 770 072 төгрөг нэмж төлүүлэн, 2 зөрчил илрүүлэн 2 300 000 төгрөгийн торгууль, нийт 200 070 072 төгрөг нэмж төлүүлсэн байна. Гаалийн мэдүүлгийн бичлэгийг 2024 оны 11-р сарын байдлаар шүүж барааны ангиллын тоо хэмжээ буруу тодорхойлсон 20, онцлог шинж, хэлцлийн тоо хэмжээг нягталж засварлах шаардлагатай 6, үнэлгээний арга буруу сонгосон 1, хүлээн авагч улс буруу бичигдсэн 5, хил дээрх тээврийн төрөл буруу сонгосон 6 мэдүүлгийг жагсаалтаар гарган засуулсан. 11-р сард аян заралсантай холбоотой зөрчил илрүүлэлтийг сайжруулах талаар анхааруулга хүргэн ажиллаж 8 зөрчил илрүүлэн шийдвэрлэж, 6 зөрчлийн гомдол мэдээллэлийг зөрчлийн хэрэг нээлгэн шийдвэрлүүлэхээр харьяаллын дагуу шилжүүлсэн байна.		
3.	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.	Япон-Монголын хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу тарифын хөнгөлөлтийг хэрэгжүүлэн ажилласан тайланг гаргаж ГЕГ-ын ТОГазарт хүргүүлэн ажиллаа. Тайлант хугацаанд Монгол улс, Япон улс хооронд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ тус хэлэлцээр, түүний 1 дүгээр хавсралт болох "Монгол Улсын тарифын жагсаалт", 2 дугаар хавсралт болох "Бүтээгдэхүүний тусгай дүрэм", МУ-ын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн гарал үүсэлтэй холбоотой 7-р бүлгийн холбогдох заалтууд, МУ-ын Засгийн газрын 2016 оны "Импортын барааны гарал үүслийн дүрэм" батлах тухай 209 дүгээр тогтоол, Гаалийн тариф, татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажилласан. 2024 онд Нэн тааламжтай тарифаар 11896.86 сая ам.доллар, ердийн тарифаар 22.7 сая ам.доллар, хөнгөлттэй тарифаар 334.9 сая ам.долларын үнийн дүн бүхий бараанд	2024.01.01 - 2024.12.10	

					гаалийн бүрдүүлэлт хийж нийт 6103.99 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Японы хөнгөлөлттэй тарифаар бүрдүүлэлт хийсэн гаалийн мэдүүлэг 17.8 хувиар буурсан бол АПТА хөнгөлөлттэй тарифаар бүрдүүлэлт хийсэн мэдүүлэг 6 дахин өссөн байна. Тайлант хугацаанд Жунмэй инженеринг групп ХХК-ний 507 горимд байршуулсан 13 техникийн бүрдүүлэлтийн хугацаа дуусан 421 горимоор гаалийн бүрдүүлэлт хийх, 507 горимоор бүрдүүлэлт хийхдээ Ердийн тариф хэрэглэсэн алдаатай мэдүүлгийг Нэн тааламжтай тарифаар тооцуулах хүсэлт гаргасны дагуу хүсэлтийг нягтлан ГЕГ-ын ТОГ, Замын-Үүд дахь гаалийн газрын хариуцсан ажилтнуудтай холбогдон БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас олгодог Гарал үүслийг нотлох бичиг баримтыг гаргуулан гаалийн бүрдүүлэлтийг хийн ажилласан. Овоот толгой ресурсес ХХК-ний 2023-09-16-нд гаалийн бүрдүүлэлт хийсэн 14-2201001-23-132103 мэдүүлэгтэй Япон улсын гарал үүсэлтэй дугуйнд Нэн тааламжтай тариф хэрэглэсэн алдааг засуулан Япон Монголын хэлэлцээрийн дагуу Хөнгөлөлттэй тарифаар гаалийн бүрдүүлэлтийг хийлгэсэн. ГЕГ-ын Татвар орлогын газрын 2024.05.30-ны 2024/63 дотоод зурвасаар илгээсэн гарал үүсэлтэй холбоотой албан бичгийн хариуг 2024.06.26-ны 92 дугаартай дотоод зурвасаар илгээн ажилласан. Тухайн дотоод зурваст дурдагдсан 02-2091010-24-131401 дугаартай мэдүүлгийн гарал үүслийг ГБМ андуурч хийсэн байсныг зөв болгуулсан бол 02-2111005-24-130325 дугаартай мэдүүлгийн алдааг засуулан 3'630'134.56 төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. Цахимаар өөрөө мэдүүлсэн иргэн, ААН-ийн хөнгөлөлттэй тарифаар андуурч илгээсэн бүрдүүлэлтийг нягтлан шалгаж дараах 24 мэдүүлгийг засуулан 227'625.07 төгрөгийн татвар нөхөн төлүүлсэн.		
4.	Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Судалгаа, дүн шинжилгээнүүд ийг гаалийн бүрдүүлэлтийн, орлогын, горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр	1. БАҮнэлгээний хэлтэсийн ГУБ А.Сакентай холбогдон Хэлцлийн үнийн баазад орсон Солонгос улсын гарал үүсэлтэй шинэ, хуучин төмрийн ялгаа гаргаж өгөх талаар саналаа өгсөн. 02-2091007-23-130215 тоосгоны алдаатай мэдүүлэг Хэлцлийн үнийн баазад орсон байсан тул мөн холбогдож устгуулсан. 6904 бүлгийн тоосгоны үнэ нэмүүлэх санал өгсөн боловч Орос улсын гарал үүсэлтэй тоосгоны үнэ нэмсэн тул бүлэг хариуцсан ГУБ Б.Должинсүрэнгээр интернэт үнэ судлуулан нийт ГУБ нарт үнийн нэмгдмэл байдлыг ханган Замын-Үүд дэх гаалийн газрын хил орчмын үнэтэй ижил үнээр хянах чиглэлийг Вайбер группээр хүргэсэн.	2024.01.01 - 2024.12.10	

				хийж, удирдлагыг мэдээллээр ханган, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сайжруулсан байна. 8. Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна.	Бэхэлгээний боолтны үнэ хэлцлийн үнийн баазад харьцангуй үнэнүүд орсон байгаа тул хянуулах хянуулах саналыг мөн ГУБ Сакенд өгсөн. Арин цэврийн хэрэглэлийн үнэ хэлцлийн үнийн баазад нэмүүлсэн. 1604.14.00 туна загас үнэ баазад хэт бага байгааг БАҮХ-ийн ГУБ Сакенд мэдэгдсэн. 4011.20.30 автоачигчийн дугуйны үнийг хянаж өгөхийг мөн хэлсэн. 72 бүлгийн төмрийн үнийг 2023.03 сарыг 2024.03 сартай харьцуулсан судалгааг хийн хүргүүлсэн. 2. Бүрдүүлэлтийнн цахим төв нь 2024.01.01-11.30-ны өдрийн байдлаар нийт 13,071.6 сая ам долларын статистик үнийн дүн бүхий 405,332 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад статистик дүн 2,461.2 сая ам.доллараар илүү буюу 23.2 хувиар, гаалийн бүрдүүлэлт 96,552 ширхэгээр илүү буюу 31.3 хувиар тус тус өсөлттэй харагдаж байна. Үүнээс: - Тус хугацаанд нийт 12255.3 сая ам.доллар бүхий 399,189 импортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад статистик дүн 2,624.45 сая ам доллар илүү буюу 27.25 хувийн өсөлттэй, 97,032 бүрдүүлэлт илүү буюу 32.11 хувийн өсөлттэй үзүүлэлттэй байна. - Нийт экспорт 816.3 сая долларын статистик дүн бүхий 6,143 экспортын бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад статистик дүн 163,2 сая ам.доллараар бага буюу 16.67 хувь, бүрдүүлэлтийн тоо 480 буюу 7.25 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тус хугацаанд 13,071,6 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 79 гаалийн бүрдүүлэлтийн горимын кодоор 405,332 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн ба нийт 6,104.73 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татвар, 4,133.2 сая төгрөгийн хураамжийг ногдуулан барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Татварын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,329.6 тэрбум төгрөгөөр буюу 27.84 хувиар, хураамжийн дүн 502.66 сая төгрөгөөр буюу 13.84 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 8. Лавлах сангийн баяжилтыг тухай бүрд нь хийн ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”

1.	Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл,	1.БТКУС-ийн хэсэгт ажиллах хугацаанд үнэ үнэлгээтэй холбоотой маргааныг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж явуулсан. Нийт 75 утасны дуудлага ирсэн үүнээс 10 иргэн, 65 аж ахуй нэгж, утасны дуудлаганд ирсэн гомдолын ихэнх хувь нь барааны үнийг өндөр үнэлсэн байна гэсэн гомдол байгааг тухай бүр байцаагчаас	2024.01.01 - 2024.12.10	
----	--	-------------------------	---	--	--	-------------------------------	--

				гомдолыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна. 2. Шийдвэрийн мэдээллийг кайс системийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байна.	тодруулан асууж ААН, иргэнтэй холбогдон тайлбарлаж гомдолын хариуг шийдвэрлэн ажиллаа. Байцаагч солиулах, үнэлгээ удаж байна, хөнгөлөлт чөлөөлөлт болон түр горимтой холбоотой асуудал, лабораторийн дүгнэлт оруулах тул буцаалгах, манифестийн дүн зөрүүтэй, хүлээн авагч засуулах гэсэн хүсэлтүүд ирсэн байна. Цахим хаягаар давхардсан тоогоор 158 и-мэйл ирсэнээс 12 иргэн, 88 ААН байгууллагын гаалийн үнэ, үнэлгээ болон бичиг баримттай холбоотой маргаан, хүсэлтийг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Мөн Бүрдүүлэлтийн цахим төвд хүсэлт өгсөн Мэтагро ХХК /6790429/ -ний 02-2181005-23-130466 мэдүүлгийг шалгаж ААН-ээс бодит байдлын байдлын зураг болон бусад мэдээллийг аван тогтоолд хамрагдахгүй байсан тул 2024.04.02-ний 01-8/1258 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. 2.Гаалийн үнэ үнэлгээтэй холбоотой санал, гомдол 24 ирснээс 3 нь гомдлоо татаж авсан, 2 нь хянагдаж байна. 19 гомдлыг "Гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлын хянасан тухай шийдвэр" гарсан байна. Дээрхи шийдвэрүүдийг кайс системийн маргаан шийдвэрийн санд бүртгэн ажилласан.		
2.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн	-	1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	ГЕГ-ын БАҮХ-тэй хамтран улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн барааны ангиллын кодыг тодорхойлон ажиллаж байна.	2024.01.01 - 2024.12.10	
3.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна.	ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-д холбогдох саналыг өгсөн. 2024.05.09-ны 62 тоот дотоод зурвасаар МТГ-т өдөр тутсын үйл ажиллагааг сайжруулах тулд КАИС СЕПС системд ойрын хугацаанд хийх шаардлагатай өөрчлөлтийн санал өгсөн.	2024.01.01 - 2024.12.10	
4.	Үүрэг	Хэрэгжилт,	-	Удирдлагаас	ГУБ Б.Энхбаяр Ж.Тунгалаг нартай хамтран өрөөний зураг	2024.01.01	

	даалгаврын биелэлт	гүйцэтгэлээр		өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	гарган, шаардлагатай тоног төхөөрөмж, эд материалын жагсаалтыг гарган хүргүүлсэн. Татвар орлогын газрын 2024/12, 2024/29 тоот дотоод зурвасаар ирүүлсэн Засгийн газрын 2023 оны 107 тогтоолд хамрагдах ААН-ийн хүсэлтийг нягтлах, Тогтоолын хэрэгжилтийг хангуулан 2023 онд хийгдсэн гаалийн бүрдүүлэлтийг нягтлан ГЕГ-ын холбогдох нэгжүүдэд хүргүүлэх чиглэлийн дагуу МУЗГ-ын 107 дугаар тогтоолд хамрагдахгүй барааны нийт 19 гаалийн мэдүүлгийг засварлаж дууссан. Тус 19 гаалийн мэдүүлгээс 14 мэдүүлэг хэлцлийн код 110 болгон зассан, 5 мэдүүлэг шинээр мэдүүлэг нэмж бичин зассан. Мөн Бүрдүүлэлтийн цахим төвд хүсэлт ирүүлсэн ААН-ийн хүсэлтийг нягтлан 107 тогтоолд хамрагдах 9 мэдүүлэгт засвар оруулан 6 мэдүүлэг нэмэлт мэдүүлэггүйгээр, 3 мэдүүлэгт барааг салган нэмэлт мэдүүлэгтэйгээр засварлан зохих төлөвт оруулан. ТОГ, СДШХэлтэст дотоод зурвасаар хүргүүлэн ажиллаа.	- 2024.12.10	
6.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Алба хаагчдын ажлын цагийг бүрэн бүртгэж, хяналт тавьсан байна. 2. Ажлын цаг ашиглалт 90 хувиас доошгүй байна.	1. Ажиллах хугацаандаа нийт ГУБ-ийн ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж ажилласан. 2. Ажлын цаг ашиглалт 76 хувьтай - ээлжийн амралт хувиарын дагуу - эмнэлэгт хэвтсэн ажлын 22 өдөр - чөлөөтэй ажлын 22 өдөр	2024.01.01 - 2024.12.10	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.							
2							

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь

	1	2	3	4	5	6	7
1.	Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор		Сургалтад бүрэн хамрагдсан байна.	2024.03.25-2024.03.29-ний хооронд УБ хотод зохион байгуулагдсан ДГБ, Японы гаалийн байгууллагаас хамтран зохион байгуулсан Гарал үүслийн сурагалтад хамрагдаж сертификат авсан. ГЕГ-ын ЭУХ-ээс хийсэн "Гаалийн хяналтын стратеги", Зам тээвэр, хөгжлийн яамаас хийсэн "Чиргүүл, чирэгч толгойн стандарт"-ын сургалтад тус тус хамрагдсан.	2024.01.01 - 2024.12.10	
2.	Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Хууль эрх зүйн мэдлэг сайжирч, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	ЗГ-аас болон ГЕГ-аас гарсан хууль тогтоомжийг цаг тухай бүрд нь уншиж судлан нийт ГУБ-т танилцуулан гаалийн бүрдүүлэлтэнд мөрдлөгө болгон ажиллахыг анхааруулж ажилласан.	2024.01.01 - 2024.12.10	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Бичиг баримт хариуцсан гаалийн улсын
ахлах байцаагч
(Албан тушаал)

..... / Ш.Наранцэцэг /
(Нэр, гарын үсэг)

2024.12.12
(Огноо)

БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ШАГДАРСҮРЭН ОВОГТОЙ НАРАНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТЭЛ, УР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
		1	2	3	4	5
		Оноо				

Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалахыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	50	20	60	
2.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа	50	20	60	
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	50	20	60	
4.	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	50	20	60	

Зорилт 2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал	51	9	60	
2.	Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил	51	9	60	
3.	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт	50	20	60	
4.	Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил	50	20	60	

Зорилт 4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал	50	20	60	
2.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	50	20	60	
3.	Үүрэг даалгаврын биелэлт	51	9	60	
4.	Ажлын цаг ашиглалт	51	9	60	

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Бүрдүүлэлтийн цахим төвийн ажлын байрны засварыг хариуцсан ажлын хэсэгт орж санаачлагатай ажилласан	50	20	60	

Дундаж оноо:					
--------------	--	--	--	--	--

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга	Нийт	Үнэлгээний
		хэмжээний биелэлтийн хувь	(15 хүртэл оноогоор)	багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Гадаад дотоод болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх	93.3 %	14	
2.	Үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах	93.3 %	14	
Дундаж оноо			14	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)				
Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
1.	Хандлага, ёс зүй	2	3	
2.	Дүн шинжилгээ хийх	7		
3.	Асуудал шийдвэрлэх	7		
4.	Хариуцлагатай байдал	7		
5.	Ажлын цаг ашиглалт	7		
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)				
6.	Мэргэжлийн ур чадвар 1.			
7.	Мэргэжлийн ур чадвар 2.			
8.	Мэргэжлийн ур чадвар 3.			
Дундаж оноо				

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)				
Д/д	Үзүүлэлт		Хамт олны үнэлгээ (0-8 оноо)	
1.	Хандлага, ёс зүй	1	2	
2.	Багаар ажиллах		8	
3.	Харилцаа		8	
Дундаж оноо				

5. Гүйцэтгэлийн үнэлгээ				
Д/д	Үнэлгээний үзүүлэлт		Үзүүлэлт тус бүрийн оноо	
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)		60	
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт		14	
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)		7	
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)		8	
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)			
Нийт оноо =				
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн				89.0

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга

(албан тушаал)

.....

/Э.Лхагвасүрэн/

(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Гаалийн улсын ахлах байцаагч

(албан тушаал)

.....

/Ш.Наранцэцэг/

(албан хаагчийн нэр)

..... 12-12... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

.....

/Г.Энхтайван/

(албан хаагчийн нэр)

12-12, 2024... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч

(албан тушаал)

.....

/Ө.Тэгшээ/

(албан хаагчийн нэр)

2024.12.20... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсөцийн шүүд захирагч

ГЕГ-ын дарга

(албан тушаал)

.....

/Р.Отгонжаргал/

(албан хаагчийн нэр)

2024.12.20... (огноо)

